



9020050420 5319

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, практик шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.2-т “Иргэний нисэхийн салбарыг даяарчлагдсан дэлхийн иргэний агаарын тээврийн бүрдэл болгох, бус нутагтаа тэргүүлэх орнуудын хэмжээнд хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарт тооцож, төрийн бодлогоор дэмжинэ” гэсэн зорилтыг тодорхойлж, мөн бодлогын баримт бичгийн 7.2-т “Агаарын тээврийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлгийг гаалийн албан татвараас хөнгөлж, чөлөөлөх бодлого баримтална.” гэж заасан.

Монгол Улс 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсон. “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн 2.1.1-д зааснаар “Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчлэх өдрөөс эхлэн гаалийн зориулалтаар Хавсралт дахь жагсаалтад харгалзах тариfyн гарчгийн дагуу ангилсан бүтээгдэхүүн болон үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, сэргээн босголт, өөрчлөлт, эсхүл хувиргалтын явцад агаарын хөлөг, эсхүл түүний угсралтад ашиглах бүтээгдэхүүний импортод ногдуулах, эсхүл түүнтэй холбогдох бүхий л гаалийн албан татвар болон бүх төрлийн бусад хураамжийг арилгах үүргийг” нэгдэн оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2-т заасан “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” зорилтын хүрээнд 2020-2030 онд иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлсэн байх зорилго, Засгийн газрын 2018 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-т ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэд хувийн хэрэгцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх зохицуулалт бүрдүүлэхээр тус тус тусгасан.

Дээрх үндэслэл, шаардлагыг харгалзан “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтыг өөрчлөн найруулахаар хуулийн төслийг боловсруулна.

## **1.2.Практик шаардлага**

Иргэний агаарын зорчигч тээврийн агаарын хөлөг, түүний сэлбэгийг 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс гаалийн албан татвараас чөлөөлснөөр агаарын тээвэр өргөжин хөгжих, нислэгийн аюулгүй ажиллагааны хангалт сайжрахад чухал ач холбогдолтой алхам болсон.

Монгол Улсад бүртгэлтэй нийт 31 агаарын хөлгийн 20 нь зорчигч тээврийн, 11 нь ерөнхий зориулалтын агаарын хөлөг болно.

“МИАТ” ТӨХК нь Европын холбоо, БНСУ, ТВУ зэрэг улс орны Иргэний нисэхийн удирдах газраас агаарын хөлгийн засвар, үйлчилгээ хийх эрх авч гэрчилгээжсэн. Сүүлийн 2 жилд гадаадын 73 агаарын хөлөгт хүнд хэлбэрийн техник үйлчилгээ хийж 25.0 тэрбум төгрөгийн орлого олж, агаарын хөлгийн сэлбэг, тоног төхөөрөмжид 777 орчим сая төгрөгийн гаалийн албан татвар төлсөн байна. Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгч “Скай жет” ХХК нь 2 жилийн хугацаанд гаалийн албан татварт 1,589,500 төгрөг, “Блу Скай Авиэйшн” ХХК нь нэг Сессна-208 агаарын хөлгийг эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар ашиглахдаа 2015-2018 оны хооронд гаалийн албан татварт 13,228,957 төгрөг тус тус төлжээ.

Ачаа тээвэр, байгаль хамгаалах, хөдөө аж ахуй, хувийн хэрэгцээний зэрэг ерөнхий зориулалтын агаарын хөлгийг татвараас чөлөөлөх замаар нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих хэрэгцээ шаардлага гарсан. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэхийн тулд агаарын хөлгийн засвар үйлчилгээ, сэлбэг хангалт, жижиг онгоц угсрах үйлдвэрлэлийг өргөжүүлэх, агаарын зайн ачаалал, ашиглалтын зардал харьцангуй бага байдлыг харгалzan нисгэгч, инженер техникийн ажилтан бэлтгэх сургалтын төвүүд байгуулах зэрэг нислэгийн үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлэх хэрэгцээ бий болсон.

Орчин үеийн, ашиглалтын зардал багатай агаарын хөлгийн парк шинэчлэлт хийх, жижиг онгоц, нисдэг тэрэгний хүртээмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлал, уул уурхай, бизнесийн нислэг, агаарын такси үйлчилгээ, хувийн онгоц ашиглахад татварын дэмжлэг шаардлагатай болсон.

Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсноор агаарын хөлөг, хөдөлгүүр, нислэгийн дадлагажуур, түүний сэлбэг тоног төхөөрөмжийг түрээсээр болон худалдан авахад илүү хялбар болж, ашиглалтыг нэмэгдүүлснээр нисэхийн салбарын хөгжилд дэмжлэг болох бөгөөд энэ Хэлэлцээрийн оролцогч талын хувьд цэргийн зориулалтын агаарын хөлгөөс бусад бүх агаарын хөлөг, түүний бүтээгдэхүүний импорт, түүнтэй холбогдох гаалийн татвар болон бусад хураамжийг арилгах, энэхүү зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжид тусгах үүрэг хүлээсэн.

**Хоёр.Хуулийн төслийн ерөнхий зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсонтой холбогдуулан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй байна. Үүнд:

1/Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтад өөрчлөлт оруулж, иргэний агаарын хөлөг болон хөдөлгүүр, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, газар дээрх дадлагажуур, холбогдох хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг тусгана.

2/Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Монгол Улсын Засгийн газар батлах гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтад дээрх заалтыг нэмж оруулахаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.6” гэсний дараа “38.1.9,” гэж нэмж тусгана.

3/Хуулийн төслийн 3 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг тусгана.

Дээр дурдсан эрх зүйн болон практик шаардлагад үндэслэн иргэний агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, холбогдох тоног төхөөрөмж, эд ангийг гаалийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг хамарна.

Энэхүү хуулийн төслийн хамрах хүрээ нь Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-ийн хавсралтад зааснаар иргэний агаарын бүх хөлөг болон хөдөлгүүр, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, газар дээрх дадлагажуур зэргээр хязгаарлагдахгүй болно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:**

Иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр, түүний эд анги, дадлагажуур, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлснөөр эмнэлгийн яаралтай тусламж, ачаа тээвэр, хөдөө аж ахуй, байгаль хамгаалал, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ зэрэг нийгэм, эдийн засгийн бүх салбарт иргэний агаарын хөлөг авч ашиглах татварын таатай орчин бүрдэнэ. Хэрэглэгчдийн өргөн сүлжээ бүхий ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлж, нисэхийн ажил, үйлчилгээний төрөл өргөжиж, ажлын байр нэмэгдэх, бизнес аялал, ачаа тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, улмаар иргэний нисэхийн салбарт хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцог нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр болон бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй уялдуулан Монгол Улсын хүчин төгөлдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагагүй болно.